

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЗАРИМ ХОЛБООС,
ТҮҮНИЙ УТГА, ҮҮРЭГ, ХЭРЭГЛЭЭ

П.Даваадорж

Хураангуй: Монгол Улсын Үндсэн хууль нь албан бичгийн тогтвортой баримт болохын сацуу бусад хууль тогтоомжийн үзэл санаа, нэр томъёо, хэл найруулгын суурь болох тул хоёрдмол утгагүй, найруулгын хэм хэмжээ зохистой байх нь чухал юм.

Тус өгүүлэлд Монгол Улсын Үндсэн хууль (1992)-д тохиолдон буй *ба, болон, бөгөөд, буюу, түүнчлэн, боловч, учир* зэрэг холбоосын утга, үүрэг, хэрэглээг тодруулан өгүүлсэн болно.

Түлхүүр үг: *холбоос, зэрэгцүүлэх холбоос, болон, бөгөөд, буюу*

1. Удиртгал. XXI зуун гарсаар салбар дундын шинжлэх ухааны хэрэгцээ эрчимжиж хэл шинжээчид хэлийг найруулгын төрөл, хэрэглээний онцлогоос нь хамааруулж олон салбартай хамтатган судлах болжээ. Үүний нэгэн салаа нь хуулийн хэлийг судлах шүүхийн/хуулийн хэл шинжлэл (*forensic linguistics*) юм. Н.Мөнхцэцэг “Шүүхийн хэл шинжлэлийн ажлын дийлэнх нь хуулийн бичгийн хэл, хуулийн ярианы хэл, мөрдөн байцаалтын хэл буюу нотлох баримт бүрдүүлэх гэсэн гурван том ангилалд хамаарна”, “Бичгийн хэлийг голлон судалдаг хэл шинжлэлийн мэргэжилтнүүд зөв бичих, өгүүлбэрийн бүтэц, үг сонголт, цэг таслал гэх мэт шинжүүдийг авч үздэг бол ярианы хэлийг голчлон судалдаг хэл шинжлэлийн мэргэжилтнүүд үгийн өргөлт, нутгийн аялгуу, дуудлага, дуу хоолойны өнгө, хурд, хэмнэл зэрэгт анхаарлаа хандуулдаг онцлогтой” (2022: 164) гэж тэмдэглэжээ. Бид энэхүү судалгаандаа бичгийн хэл, тэр дундаа албан бичгийн тогтвортой баримт болох 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийг эх хэрэглэгдэхүүн болгон зарим холбоосыг хэрхэн хэрэглэсэн байдлыг тодруулахыг зорьсон болно.

Монгол Улсын Үндсэн хуулийг хэл шинжлэлийн талаас тусгайлан судалсан бүтээл ховор боловч үгийн сан, найруулгын тухай судалгаа ойрын хэдэн жил эрчимжиж байна. Тухайлбал, С.Өмербик “Хуулийн бичвэр дэх зарим холбох үгийн хэрэглээ” (2020) өгүүлэлдээ холбоос үгийг албан бичгийн найруулгад судлахын чухлыг “Хэд хэдэн холбох үгс орсон, хавсарсан нийлмэл өгүүлбэртэй хуулийн бичвэрийг тайлбарлахаас өмнө түүнд хэрэглэсэн холбох үгсийн утга агуулга, зориулалт, үүрэг, хэрэглэгдэж буй учир шалтгаан (логик), найруулга зүйн нарийн зүй тогтол зэргийг сайтар танин мэдэж, судлах шаардлагатай. Олон холбох үг орсон хуулийн заалтыг ойлгоход бэрх, ээдрээтэй болж, салаа утгаар тайлбарлагдан, буруу хэрэглэснээс эцэст нь практикт хуульчдын дунд багагүй маргаан үүсдэг” болохыг тэмдэглээд 1992 оны “Үндсэн хууль”-д тохиолдон буй “ба, бөгөөд, буюу, эсхүл, болон, харин, түүнчлэн”¹ зэрэг холбоосын давтамжийг тэмдэглэн, найруулгад зөв хэрэглэсэн эсэхийг жишээ татан өгүүлж, 1992 оны “Үндсэн хууль”-д буюу холбоосыг 24 удаа хэрэглэхдээ 15-д нь найруулгын алдаа гаргасан болохыг хэрэглэгдэхүүний баримтаар нотолжээ. Мөн тэрээр “бөгөөд, болоод, хийгээд, болон” холбоосын утга: а. эдгээр нь хоорондоо ижил утга, агуулгатай тул бие биеэ орлох, найруулах

¹ Хүснэгт 1-ээс тус өгүүлэл болон бусад судалгаанд холбоосын тохиолдсон тоог хэрхэн тэмдэглэсэн болохыг харж болно.

боломжтой. “Бөгөөд” холбоосын утгыг “болоод, хийгээд”-тэй сольж, оруулах боломжтой боловч “болон” холбох үгтэй солих боломжгүй” хэмээн анхааруулж судлаачид лавшруулан судлах шаардлагатайг дурдсан байна. Ж.Бат-Ирээдүй “Монгол Улсын Үндсэн Хууль (1992) дахь холбоос үгийн утга найруулгын тухай асуудалд” (2021) хэмээх өгүүлэлдээ “1992 оны Үндсэн хуулийн найруулгад хэдийгээр өөр өөрсдийн утгын нарийн ялгааг гаргаж зохих хэл зүй, найруулгын үүргээр хэрэглэгдэж байгаа боловч буюу зэрэг зарим нэгэн холбоосыг хэрэглэхдээ утгыг буруу ухаж, солин найруулсан байх нь элбэг” (2021: 87) байгааг дурдаж холбоосыг буруу найруулсан 11 жишээ²-ээр өгүүлэн, найруулгын алдаа мэдгийг залруулах нь тулгамдсан асуудал болохыг тэмдэглэжээ.

Б.Өнөрмаа “Хуулийн хэрэглээ буюу эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан “давтан бүлэглэж буюу урьдчилан үгсэн тохиролцсон” гэх өгөгдлийн талаар” хэмээх өгүүлэлдээ “Үг зүйн “буюу”-г “эсхүл” гэдэгтэй утга нэг гэж тайлбарлаж хэрэглэж байгаа нь хуулийг нэг мөр ойлгоход бэрхшээл учруулж байна”, “хуулийн зохицуулалт алдаатай, хоёрдмол санаа бүхий үгээр томьёолсон, хэт олон холбоос үгтэй бол түүнийг хэрэглэх эрх бүхий хийгээд бусад этгээдүүд өөр өөрсдийнхөө үзэл бодлоор бие биенээсээ зөрүүтэй ойлгож хуулийг хэрэглэж байгаагийн бодит жишээ бол ЭХТА-ийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан “давтан бүлэглэж буюу урьдчилан үгсэн тохиролцож” гэсэн хүндрүүлэх бүрэлдэхүүн юм” гээд “ЭХТА-ийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан зөвхөн “давтан” “бүлэглэж” гэсэн хүндрүүлэх нөхцөлөөр хэрэг шийдвэрлэгдэж байгаа практикийг судлахад урьд нь хулгайн гэмт хэрэг үйлдээгүй боловч бүлэглэн үйлдсэн тохиолдолд “бүлэглэж үйлдсэн”, давтан үйлдлээр хулгай хийсэн тохиолдолд “давтан” хэмээн “давтан бүлэглэж буюу урьдчилан үгсэн тохиролцож” гэснийг тус тусад нь салган “давтан бүлэглэж гэсэн нөхцөлийн дунд дураараа таслал тавьж” яллах дүгнэлт үйлдэж, ял шийтгэл оногдуулж хэвшжээ” (www.mglbar.mn/news/1721) хэмээжээ. Ер нь хэл шинжлэлийн талаас нэгдүгээрт, буюу болон эсхүл холбоосыг нэг утга илтгэнэ гэж тайлбарлах нь өрөөсгөл; хоёрдугаарт, хуульчид холбоосын утгыг буруу ухсанаас үүдэж практикт учирч байгаа зөрчил болохыг харж болохоор байна. Иймийн тул 1992 оны Үндсэн хуульд тохиолдон буй холбоосыг бүртгэн гаргаж найруулгын алдаа мадаг байгаа эсэхийг лавшруулан судлах нь чухал байна.

2. Судалгааны хэсэг

Орчин цагийн монгол хэлэнд холбоосыг туслах үгийн аймагт хамааруулж, үгийн сангийн утга онооход төвөгтэй ч салангид үг, өгүүлбэрүүдийг холбох үүрэгтэй тул найруулга зүйд чухал байрыг эзэлж буйг тэмдэглэсээр иржээ. 1992 оны “Үндсэн хууль”-ийн холбоосыг судалсан судлаачид тус тусын ажилдаа зэрэгцүүлэх холбоосыг авч үзсэн байдаг (Үүнийг хүснэгт 1-ээс харна уу). “Зэрэгцүүлэх холбоосыг дотор нь холбож байгаа шинжээр нь нэгдүгээрт, ялгаж холбох холбоос (ба, болоод, болон, бөгөөд, агаад, хийгээд), хоёрдугаарт, адилтгаж холбох холбоос (буюу, өөрөөр хэлбэл) гэж ангилж болно. Учир нь ба, болон, болоод, бөгөөд, агаад, хийгээд зэрэг холбоос зэрэгцсэн гишүүн, зэрэгцсэн өгүүлбэрийг ялган тодруулдаг тул ялгах үүрэгтэй, “буюу, өөрөөр хэлбэл” холбоос чанарын хувьд нэг л юмыг зааж холбодог тул нэгтгэх, (нэг болохыг заах) үүрэгтэй байна.” (Отгонсүрэн, 1978: 18) хэмээн үзэж ирсэн уламжлал бий. Ж.Баянсан нар “өгүүлбэрийн гишүүдийн хэл зүйн холбоог заадаг ба, бөгөөд, буюу, хийгээд, болон гэх зэрэг холбоос үгийг дотоод холбоос гэж тодорхойлжээ. Монгол хэлний дотоод холбоос үгийг гүйцэтгэх үүрэг, шинжид нь тулгуурлаж, зааглах ба холбох гэж ангилдаг” (1995: 246)” хэмээжээ. Эдгээр холбоосыг үүргийн талаас нь гишүүдийг зэрэгцүүлэн холбосон *ба, болон, бөгөөд, хийгээд, буюу*; өгүүлбэрүүдийг зэрэгцүүлэн холбосон *эсхүл (эсвэл), түүнчлэн* гэж ангилж болно. Энэ талаар Ц.Пүрэв-Очир “Хэлний баримтыг ажиглаж байхад монгол хэлэнд үүний зэрэгцээ, үүнээс гадна, түүнээс гадна, түүнчлэн, түүний сацуу, бас, харин гэх мэт өгүүлбэр цогцолбор эхийг зэрэгцүүлэн холбодог гадаад холбох үг байдаг. Эдгээр нь

² Хэрэглэгдэхүүн нэг тул тус 11 жишээ С.Өмөрбикийнхтэй ижил юм.

дундаас нь зэрэгцүүлэн холбодог ба, бөгөөд, эсвэл, буюу, агаад, хийгээд, болон, байтугай, бол, төдийгүй гэх мэтээс арай өөр байрлалтай, өөр үүрэгтэйг ташрамд дурдъя” (2000: 29) хэмээн тэмдэглэснийг анхаарахгүй өнгөрч болохгүй юм. Гэхдээ “Орчин цагийн монгол хэлний зэрэгцүүлэн холбох үгийг гишүүдийг холбох, өгүүлбэрүүдийг холбох гэж ангилж байгаа нь харьцангуй ойлголт юм. Учир нь гишүүдийг зэрэгцүүлэн холбох үг нь өгүүлбэрүүдийг холбох, өгүүлбэрүүдийг зэрэгцүүлэн холбох үг нь гишүүдийг холбох нь олонтоо тохиолдоно. Иймээс хам бүтэц дэх үүргийг гол болгож ангилах нь зүйтэй” (Жумдаан нар, 2022: 179) хэмээснийг харгалзан үзэж, хам бичвэрээс хамаарч тус холбоос 1992 оны Үндсэн хуульд ямар үүргээр орсныг судалгааны явцад илүү тодорхой болгох юм. Бид энэхүү судалгаандаа доорх хүснэгтэд тэмдэглэсэн холбоос үгийн утга, үүрэг, давтамж зэргийг тодруулахыг хичээлээ.

Хүснэгт 1

№	Холбоос	С.Өмөрбик (2020)	Ж.Бат-Ирээдүй (2021)	Бичгийн хэл (2022)	Эл судалгаанд (2023)
1.	ба	8	3	8	8
2.	болон	27	3	27	26 ³
3.	бөгөөд	19	4	23	19 ⁴
4.	хийгээд	-	1	-	2
5.	буюу	24	11	24	24
6.	эсхүл	8	-	8	8
7.	түүнчлэн	10	-	-	10
8.	боловч	-	-	-	3
9.	учир	-	-	-	2

Зэрэгцүүлэх холбоосын тухай судлаачид ямар байр суурьтай байгааг товч авч үзээд холбоос бүр хам бичвэрт ямар утга, үүрэг илтгэж буйг тайлбарлахыг оролдъё.

Үүнд:

1. “Орчин цагийн монгол хэлний холбох үг нь энгийн ба хавсарсан нийлмэл өгүүлбэр болон өгүүлбэрийн доторх зэрэгцсэн гишүүдийг холбох, ялган салгах үүрэгтэй орсон хэл зүйн хувиллаар хувирах шинж багатай байдаг. Монгол хэлний энэ бүлэг нэгжийн үгзүйн онцлогийг ажиглахад зэрэгцүүлэн холбох буюу холбоос үг (уламжлалт) нь нэр ба үйлийн хувиллаар огт хувилдаггүй бөгөөд зарим хэсэг нь монгол хэлний хөгжлийн явцад үйл үгээс үүссэн тул үйл үгийн хэлбэртэй нөгөө хэсэг нь тийн ялгалаар хэлбэржсэн төлөөний үгийн хэлбэртэй байгаа бол захируулан холбох үг нь нэрийн хувиллаар заримдаг хувилдаг тул нэр үгээс үүсэлтэй хэмээн үздэг” (Мөнхцэцэг, 2014: 42);
2. Зэрэгцүүлэх холбоос нь “Үг, өгүүлбэрийн доторх зэрэгцсэн гишүүд, нийлмэл өгүүлбэрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг холбох, ялгах үүрэг бүхий туслах үгс ...” (Цэрэнчимэд нар, 2022: 29) юм. Иймийн тул өгүүлбэрийн найруулгатай холбогдоно. “Өгүүлбэрийн найруулгын хэм хэмжээ гэдэг нь холбоо үг, гишүүдийн байр, холбоос үгийн зохист байрын тухай асуудал юм” (Баттогтох, 2022: 156);
3. Тиймээс холбоосын зохих байр, найруулгын зохист хэрэглээний тухай өгүүлэх нь чухал ажээ. Зэрэгцүүлэх холбоосын үүргийн тухай Ц.Өнөрбаян “Өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүд болон энгийн нийлмэл өгүүлбэр, салангид өгүүлбэрүүд, догол мөр зэргийг холбох үүрэгтэй ...” (2004: 317)-г дурдсан бол Л.Жумдаан “Салангид өгүүлбэрүүд болон өгүүлбэрийн

³ 2019 оны 11 сарын 14-ий нэмэлт өөрчлөлтөөр “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно” хэмээх хэсгийг 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсон” тул 26 холбоос байна хэмээн үзэв.

⁴ Тус холбоос нь 1992 оны Үндсэн хуульд 23 удаа тохиолдож байгаа хэдий ч 4 тохиолдол нь тухайн заалт хэзээ хэрэгжиж эхэлсэн болоод хэзээнээс хүчингүй болгосон зэргийг тэмдэглэж байгаа тул Үндсэн хуулийн бичвэрт шууд хамаарахгүй юм.

гишүүдийг холбох үүрэгтэй *ба, бөгөөд, буюу, харин, хэрэв, өөрөөр хэлбэл, болон, эсвэл, нэг бол, гэтэл, гэвч, иймээс, бас, төлөө, тул, талаар, тухай, турш, шиг, мэт, барахгүй, байтугай, учир, улмаас* гэх мэт үгийг холбох үг гэнэ.” (2022: 175) хэмээсэн байдаг. Ер нь холбоосыг хам бичвэрээс хамаарах утгад нь тулгуурлан А.Цог-Очир нар дараах байдлаар ангилан авч үзжээ (2022: 29).

№	Утга	Холбоос үг
1.	зэрэгцүүлэх, салгах, хоёр гэсэн утгыг тухайлах	ба - үүсмэл бус холбоос
2.	салгах, тусгаарлах, тоочин тодорхойлох, зэрэгцүүлэх	бөгөөд, агаад, хийгээд, болон, болоод
3.	тодорхой тоон утгыг тухайлах, зэрэгцлийн эгнээг хааж холбох	хоёр, гурав, дөрөв гэх мэт тооны нэрээр холбоно
4.	эсрэгцүүлэх, утгыг эргүүлэх	харин, -даг бол, гэвч, боловч, авч, гэхдээ, гэтэл, бол харин, -х+д харин, бус биш, атал, мөртөө
5.	лавшруулах, ахиулах, чухалчлах	байтугай, тэр ч байтугай түүнчлэн, ...зогсохгүй, цаашилбал, үл барам, -аас ⁴ , гадна, төдийгүй, төдий биш бүр, бүү хэл, битгий хэл, хэрнээ
6.	болзон сонгох	эсвэл (эсхүл), юм уу эсвэл, аль эсвэл, нэг бол, үгүй бол
7.	тодосгох	буюу, өөрөөр хэлбэл
8.	онцлон чухалчлах	ялангуяа, нэн ялангуяа, мөн, мөнхүү, бас, басхүү
9.	нэгтгэн ерөнхийлөх	гэх мэт, гэх зэрэг, зэрэг, тэргүүтэн

Энэхүү ангилал нь тухайн холбоосын илтгэх утгыг тодруулахад ихээхэн нэмэр болох юм.

1. *Ба* холбоосын тухай: “Холбоос “ба” нь орчин цагийн бичгийн хэлэнд өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүнийг зааглан, холбох үүрэг гүйцэтгэнэ” (Амаржаргал, 1976: 68). Мөн судлаач Б.Пүрэв-Очир “Ба-гаар үгсийг, гишүүдийг, зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийг холбоход ерөнхийдөө хоёрхон эгнээтэй битүү холбоо үүсгэдэг. Жишээ нь: чоно ба хурга, Улааныхан ба харынхан, баян ба ядуу ...” (2001: 35) болохыг мөн дурджээ. Бид дээрх хүснэгтээс зэрэгцүүлэх, салгах утга илтгэхийг харж болохоор байна. Тус холбоос нь 1992 оны “Үндсэн хууль”-д 8 удаа⁵ тохиолдохдоо 2 удаа зэрэгцүүлэх, 6 удаа салгах утгаар тус тус хэрэглэгджээ.

2. *Болон* холбоосын тухай: Тус холбоос нь *бол-* язгуурт, үйлийн зэрэгцүүлэн холбох “-н” бүтээвэр залган хэвшсэн холбоос үг юм. “*Болон* зэрэгцүүлэн холбох үг нь өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүдийг зааглах, тэгш эрхтэй болгох үүрэгтэй” (Мөнхцэцэг, 2014: 117). Эл холбоосыг өмнөх судлаачид “Үндсэн хууль”-д 27 удаа тохиолдож байна хэмээн тэмдэглэсэн байдаг ч 26 удаа тохиолдон буйг дээр өгүүлсэн билээ. *Болон* холбоос нь 1992 оны “Үндсэн хууль”-д 26 удаа тохиолдож байгаагаас 14 удаа салгах утгаар, 10 удаа тусгаарлах утгаар, 2 удаа тоочин тодорхойлох утгаар тус тус хэрэглэгджээ. 1 удаа зохих холбоосыг хэрэглээгүйгээс найруулгын алдаа гарчээ. Үндсэн хуулийн 49-р зүйлийн 6 хэсэгт *түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах* хэмээн *болон* холбоосыг хэрэглэсэн нь нэгдүгээрт, түдгэлзүүлнэ эсвэл огцруулна түүний дараа сахилгын бусад шийтгэлийн ногдуулан; хоёрдугаарт, эсвэл түдгэлзүүлнэ, эсвэл огцруулна, эсвэл сахилгын шийтгэл ноогдуулна хэмээн өөр өөрөөр ойлгож, тайлбарлаж болохоор байгаа нь “Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйл”-д “үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих” гэсэн заалттай зөрчилдөж байна.

3. *Бөгөөд* холбоосын тухай: Уламжлалт монгол хэл зүйн бичгүүдэд “...Үлдэгдэлт үг нь номлосон *бөгөөд, тэр бөгөөд, энэ мэт бөгөөд, санаад, сэтгээд* мэт болой. Юуны тул үлдэгдэлт үг хэмээвээс, номлох утга эс дууссаны тул болой” (Пагва, 1957: 16) хэмээн тэмдэглэсэн нь бий. “Орчин цагийн монгол хэлний зэрэгцүүлэн холбох үг нь өгүүлбэрийн эхэнд дурдсан

⁵ Хавсралт хэсгээс Үндсэн хуулийн хэд дүгээр зүйлийн хэд дэх хэсэгт тохиолдон буйг харж болно.

санааг дараачийн хэсэгт гүнзгийрүүлэн лавшруулж бататгах буюу өгүүлбэрийн уг хоёр хэсгийг зэрэгцүүлж холбох үүргээр ..." (Мөнхцэцэг, 2019: 119) тохиолдон буйг судлаачид тэмдэглэсэн байна. Мөн дээр тэмдэглэсэн хүснэгтээс утга санааг тоочин тодорхойлох, салгах тусгаарлах, зэрэгцүүлэх утгуудыг илтгэдэг болохыг харж болно. Тус холбоос нь 1992 оны "Үндсэн хууль"-д 9 удаа салгах утгаар, 9 удаа тусгаарлах утгаар тохиолдож байна. Хэдий тийм ч 68-р зүйлийн 1-д *Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно* хэмээсэн нь нэгдүгээрт, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санаачилгыг гаргах хуулийн этгээд Үндсэн хуулийн цэцэд санал гаргаснаар Үндсэн хуулийн цэц УИХ-д өргөн мэдүүлэх; хоёрдугаарт, Үндсэн хуулийн цэц болон УИХ-ын аль алинд нь өргөн мэдүүлэх мэтээр 2 янзаар ойлгогдож байгаа нь бас л "Хууль тогтоомжийн тухай хууль"-ийн 30 дугаар зүйлтэй зөрчилдөж байна.

4. *Хийгээд* холбоосын тухай: *Хийгээд* холбоос нь үйлийн зэрэгцүүлэн холбохын -ээд нөхцөлөөр хэлбэржин хэвшсэн, өгүүлбэрт салгах, тусгаарлах, тоочин тодорхойлох, зэрэгцүүлэх утгаар тохиолдож өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүдийг холбох үүрэгтэй холбоос юм. Эл холбоос нь 1992 оны Үндсэн хуульд тусгаарлах утгаар 1, зэрэгцүүлэх утгаар 1 удаа тус тус тохиолдож байна.

5. *Буюу* холбоосын тухай: Өмербик (2020), Ж.Бат-Ирээдүй (2021) нар тус тусын судалгаандаа буюу холбоосын утга, үүргийн тухай дэлгэрэнгүй өгүүлээд Өмербик 15 удаа эсхүл холбоосын оронд буруу хэрэглэсэн болохыг; Ж.Бат-Ирээдүй найруулгын алдаатай 11 жишээ татаж "Үндсэн хууль"-ийг англи хэл рүү орчуулахдаа ог буюу эсвэл гэдэг утгаар орчуулсан нь оновчтой тухай тус тус тэмдэглэсэн байна. Тус холбоос 1992 оны "Үндсэн хууль"-д 24 удаа тохиолдож байгаагаас 22-т нь зохих холбоосыг хэрэглээгүйгээс найруулгын алдаа гарчээ. Хавсралт хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

6. *Эсхүл (эсвэл)* холбоосын тухай: Тус холбоос нь болзон сонгох утгыг илтгэнэ. 1992 оны "Үндсэн хууль"-д 8 удаа тохиолдож байна.

7. *Түүнчлэн* холбоосын тухай: Эл холбоос нь голдуу салангид өгүүлбэрүүдийг зэрэгцүүлэн холбодог хэмээн үзэж болох ч хам бичвэрийн үүргээс шалтгаалж зэрэгцсэн гишүүдийг ч холбох тул харьцангуй ойлголт болохыг судлаачид дурдсан байдгийг өмнө тэмдэглэсэн. Тус холбоос нь 1992 оны "Үндсэн хууль"-д 10 удаа лавшруулах утгаар тохиолджээ.

8. *Боловч* холбоосын тухай: Эл холбоос нь эсрэгцүүлэх болон утгыг эргүүлэх санааг илтгэх хэдий ч 1992 оны "Үндсэн хууль"-д 3 удаа тохиолдохдоо хэн гэх үгтэй хоршиж хэн боловч хэмээхэд олноос онцлох (Ерөнхийлөгч ч, Ерөнхий сайд ч шүүгч шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй) утгаар, хэнд боловч гэхэд олны утгаар тус тус тохиолдож байна. Ингэхдээ холбоосын үүргээр ороогүй байна. Үүнтэй адил *мөн* гэх батлах утгатай туслах үг, *бөгөөд* холбоос үгтэй хоршин батлан лавшруулах утгаар 4 удаа тохиолдож байна. Ер нь туслах үг, туслах үгтэй хорших хэлний эл үзэгдэл нь нэг талаас холбоос үгийн найруулгын нэгэн онцлогийг нөгөө талаас хоршоо үг үүсэх нэг аргыг гэрчилж байгаагаараа онцлог юм.

9. *Учир* холбоосын тухай: Тус холбоос нь 1992 оны "Үндсэн хууль"-д 2 удаа салангид өгүүлбэрүүдийг зэрэгцүүлэн холбох үүргээр тохиолдож байна. Жишээ нь: "Үндсэн хууль"-ийн 10 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт *амьд явах эрхтэй. Монгол Улсын эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь насыг бусниулахыг хатуу хориглоно* хэмээсэн хэсгийн утга санаа баахан саармагшжээ. Учир юу гэвээс тус өгүүлбэрийг задлан тайлбарлавал ("Эрүүгийн хууль"-д 2017 оноос эхлэн цаазын ял үйлдэхийг хориглосон заалт хэрэгжиж эхэлсэнтэй холбон ойлговол) найруулгын алдаа улам ялгаран харагдах юм. Тус өгүүлбэр нь 1. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц гэмт хэрэг үйлдсэн *учир* 2.

шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас 3. бусад тохиолдолд хүний амь насыг бусниулахыг хатуу хориглоно хэмээх 3 өгүүлбэр болон задарна. Эл өгүүлбэрт тохиолдон буй *учир* гэх холбоос нь 1 болон 2 дугаар өгүүлбэрийг холбох үүргийг гүйцэтгэсэн бол 2 ба 3 дугаар өгүүлбэрийг холбон найруулахдаа ...-аас *бусад тохиолдолд* хэмээснээр үг буруу сонгож, утга санааг бүрхэгдүүлснийг харж болно. -аас *бусад тохиолдолд*-ыг мөн нэхэн тодруулбал *Монгол Улсын эрүүгийн хуульд заасан онц гэмт хэрэг үйлдсэн учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулсан*-тай буюу *хүний амь насыг бусниулахтай* холбогдох юм. Монгол Улсын Эрүүгийн хууль 2015 онд шинэчлэн батлагдаж 2017 оноос цаазаар авах ялыг халсан атал 1992 онд батлагдсан шинэ “Үндсэн хууль”-даа 2019 онд нэмэлт өөрчлөлт оруулахад тус заалтын найруулгыг хэвээр нь үлдээсэн нь ихэд сонирхолтой байна.

3. Дүгнэлт

1992 оны Үндсэн хуульд *болон, бөгөөд, буюу* зэрэг холбоосын утгыг ухаагүйгээс найруулгын алдаа гарсан байна. Мөн хэл найруулгын алдаанаас хамаарч “Үндсэн хууль”-ийн үзэл санаа өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Эрүүгийн хууль”-ийн заалттай зөрчилдөж байна. Хэл шинжээчид эдгээр холбоосыг буруу найруулсан, тус хуульд үг буруу сонгон хэрэглэснээс найруулгын ийм алдаа гарчээ гэж дурдахаас биш хэрхэн зөв найруулах, батлах нь УИХ-ын бүрэн эрхийн асуудал тул шинэ “Үндсэн хууль”-д дахин өөрчлөлт оруулахдаа эдгээр холбоос болон дээр дурдсан найруулгын алдаатай өгүүлбэрийг зөвөөр солин найруулахгүй бол суурь хуулийн үзэл санаа хоёрдож, үүнээс үүдэж аль ч этгээд өөрт тааруулж тайлбарлан мушгиж болох сөрөг талтай байна.

Ном зүй

- Амаржаргал Б.** 1976. *Бичгийн хэлэнд зарим холбоосыг хэрэглэсэн байдал*. ШУА сэтгүүл. 67-70 дахь тал.
- Бат-Ирээдүй Ж.** 2021. *“Монгол Улсын Үндсэн Хууль” (1992) дахь холбоос үгийн утга найруулгын тухай асуудалд. “Хэрэглээний хэл шинжлэл”* сэтгүүл. Том VI. Улаанбаатар. 81-88 дэх тал.
- Баттогтох Г., нар.** 2022. *Бичгийн хэл*. Монгол хэл судлал-ХІІІ боть. Улаанбаатар.
- Баянсан Ж., Одонтөр Ш.** 1995. *Хэл шинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн тайлбар толь*. Улаанбаатар.
- Мөнхцэцэг Н.** 2020. *Хэрэглээний хэл шинжлэл*. Монгол хэл судлал-ХV боть. Улаанбаатар.
- Жумдаан Л., нар.** 2022. *Үг зүй*. Монгол хэл судлал-ІХ боть. Улаанбаатар.
- Өнөрбаян Ц.** 2004. *Орчин цагийн монгол хэлний үг зүй*. Улаанбаатар.
- Отгонсүрэн Д.** 1978. *Монгол хэлний холбоос үгийн найруулгын үүрэг*. Улаанбаатар.
- Цог-Очир А., нар.** 2022. *Өгүүлбэр зүй*. Монгол хэл судлал-ХІ боть. Улаанбаатар.
- Пагва Т.** 1957. *Зүрхэн тольтын тайлбарыг судалсан тухай*. Улаанбаатар.
- Пүрэв-Очир Б.** 2000. *Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй*. Улаанбаатар.
- Пүрэв-Очир Б.** 2001. *Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүй*. Улаанбаатар.

Цахим сурвалж

- Өнөрмаа Б.** *Хуулийн хэрэглээ буюу эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан “давтан бүлэглэж буюу урьдчилан үгсэн тохиролцсон” гэх өгөгдлийн талаар*. www.mglbar.mn/news/1721.
- Өмербик С.** 2020. *Хуулийн бичвэр дэх зарим холбох үгийн хэрэглээ*. <https://omir.coo.mn/116518/>.
- Монгол Улсын Үндсэн хууль*. 1992. Legalinfo.mn.
- Монгол Улсын Эрүүгийн хууль*. 2015. Legalinfo.mn.
- Хууль тогтоомжийн тухай хууль*. 2015. Legalinfo.mn.

ХАВСРАЛТ

№	Холбоос	Жишээ	Утга
Ба холбоос			
1.	ба	6-р зүйлийн 2. одооны <i>ба</i> ирээдүй үеийн иргэн бүрд	зэрэгцүүлэх
2.	ба	6-р зүйлийн 3. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн <i>ба</i> улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг	зэрэгцүүлэх
3.	ба	10-р зүйлийн 13. Иргэний хувийн <i>ба</i> гэр бүл, захидал харилцааны нууц	салгах
4.	ба	22-р зүйлийн 1. дайны <i>ба</i> нийтийн эмх замбараагүй байдал үүссэн	салгах
5.	ба	25-р зүйлийн 3. Ерөнхийлөгчийн <i>ба</i> Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах	салгах
6.	ба	38-р зүйлийн 3. салбарын <i>ба</i> салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар	салгах
7.	ба	49-р зүйлийн 2. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын <i>ба</i> Засгийн газрын гишүүн	салгах
8.	ба	66-р зүйлийн 2. ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний <i>ба</i> Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх	салгах
Болон холбоос			
1.	болон	5-р зүйлийн 2. Төр нь нийтийн <i>болон</i> хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч	салгах
2.	болон	5-р зүйлийн 4. аж ахуйн бүх хэвшлийн <i>болон</i> хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн	тусгаарлах
3.	болон	6-р зүйлийн 1. ургамал <i>болон</i> байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.	тусгаарлах
4.	болон	6-р зүйлийн 5. хугацаатайгаар <i>болон</i> хуульд заасан бусад болзол, журмаа	тусгаарлах
5.	болон	16-р зүйлийн 5. өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах <i>болон</i> хуульд заасан бусад тохиолдолд	тоочин тодорхойлох
6.	болон	16-р зүйлийн 10. нийгмийн <i>болон</i> өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс	салгах
7.	болон	16-р зүйлийн 10. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө <i>болон</i> гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно.	салгах
8.	болон	16-р зүйлийн 14. ... өөрийн <i>болон</i> гэр бүлийн гишүүд	салгах
9.	болон	16-р зүйлийн 18. үндэсний <i>болон</i> хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.	салгах
10.	болон	18-р зүйлийн 5. үндэсний <i>болон</i> хүн амын аюулгүй байдлыг хангах	салгах
11.	болон	19-р зүйлийн 1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн <i>болон</i> бусад баталгааг бүрдүүлэх	тоочин тодорхойлох
12.	болон	19-р зүйлийн 2. Онц <i>болон</i> дайны байдал зарласан тохиолдолд	тусгаарлах
13.	болон	25-р зүйлийн 7. хөгжлийн <i>болон</i> үндэсний аюулгүй байдлын бодлогод	тусгаарлах
14.	болон	25-р зүйлийн 7. төсвийн зарлагын <i>болон</i> алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно.	салгах

15.	болон	25-р зүйлийн 12. нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын тогтолцоо	салгах
16.	болон	25-р зүйлийн 18. энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөлд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах эсхүл энэ тухай гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, хүчингүй болгох	тусгаарлах
17.	болон	27-р зүйлийн 5. Ерөнхийлөгч онц болон дайны байдал зарлавал	тусгаарлах
18.	болон	27-р зүйлийн 6. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг	салгах
19.	болон	28-р зүйлийн 2. Байнгын болон бусад хорооны бүрэн эрх	салгах
20.	болон	33-р зүйлийн 1.12. онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх	тусгаарлах
21.	болон	33-р зүйлийн 3. нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах	тусгаарлах
22.	болон	44-р зүйлийн 1. Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар	тусгаарлах
23.	болон	49-р зүйлийн 6. Түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах	Буруу хэрэглэсэн (эсвэл /эсхүл/ холбоосыг хэрэглэвэл тохиромжтой)
24.	болон	50-р зүйлийн 1.2. давж заалдах болон хяналтын журмаар	салгах
25.	болон	57-р зүйлийн 2. улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын	салгах
26.	болон	59-р зүйлийн 3. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн.	салгах
27.	болон	39-р зүйлд Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн- Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно." гэснийг 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсон./	салгах
Бөгөөд холбоос			
1.	бөгөөд	5-р зүйлийн 5. Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна.	тусгаарлах
2.	бөгөөд	20-р зүйл. Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.	салгах
3.	бөгөөд	23-р зүйлийн 1. ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.	салгах
4.	бөгөөд	24-р зүйлийн 2. бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байх бөгөөд хуульд заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө чөлөөлж, огцруулж болно.	салгах
5.	бөгөөд	25-р зүйлийн 1. бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.	тусгаарлах
6.	бөгөөд	25-р зүйлийн 1.16. аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд мөнхүү зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно	салгах

7.	бөгөөд	26-р зүйлийн 1. Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх <i>бөгөөд</i> энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно	салгах
8.	бөгөөд	26-р зүйлийн 3. Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх <i>бөгөөд</i> хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол	салгах
9.	бөгөөд	45-р зүйлийн 1. Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах <i>бөгөөд</i> түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна.	тусгаарлах
10.	бөгөөд	46-р зүйлийн 2. Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх <i>бөгөөд</i> Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана.	тусгаарлах
11.	бөгөөд	48-р зүйлийн 1. Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх <i>бөгөөд</i> шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно.	салгах
12.	бөгөөд	49-р зүйлийн 5. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно.	тусгаарлах
13.	бөгөөд	49-р зүйлийн 6. Шүүхийн сахилгын хороо ажиллах <i>бөгөөд</i> түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.	тусгаарлах
14.	бөгөөд	50-р зүйлийн 1. Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн <i>бөгөөд</i> дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	салгах
15.	бөгөөд	50-р зүйлийн 2. Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх <i>бөгөөд</i> түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ.	тусгаарлах
16.	бөгөөд	53-р зүйлийн 2. Монгол хэл мэдэхгүй хүнд хэргийн баримт сэлтийг хэлмэрчлүүлэн бүрэн танилцуулах бөгөөд шүүх хуралдаан дээр эх хэлээр нь үг хэлэх эрх олгоно.	тусгаарлах
17.	бөгөөд	63-р зүйлийн 2. Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх <i>бөгөөд</i> түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.	салгах
18.	бөгөөд	64-р зүйлийн 2. Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах <i>бөгөөд</i> аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.	тусгаарлах
19.	бөгөөд	68-р зүйлийн 1. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах <i>бөгөөд</i> саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.	Буруу хэрэглэсэн (эсвэл /эсхүл/ холбоосыг хэрэглэвэл тохиромжтой)

Хийгээд холбоос			
1.	хийгээд	15-р зүйлийн 1. Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно.	тусгаарлах
2.	хийгээд	18-р зүйлийн 4. Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно.	зэрэгцүүлэх
Буюу холбоос ⁶			
1.	буюу	6-р зүйлийн 4. нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах	эсхүл (эсвэл)
2.	буюу	10-р зүйлийн 3. 3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц	эсхүл (эсвэл)
3.	буюу	16-р зүйлийн 9. шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй.	эсхүл (эсвэл)
4.	буюу	16-р зүйлийн 18. улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох	эсхүл (эсвэл)
5.	буюу	22-р зүйлийн 1. Улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсгийг нь хамарсан гэнэтийн аюул тохиолдсон	эсхүл (эсвэл)
6.	буюу	25-р зүйлийн 1.18. улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах	эсхүл (эсвэл)
7.	буюу	25-р зүйлийн 2.1. улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн	эсхүл (эсвэл)
8.	буюу	25-р зүйлийн 2.1 нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг	эсхүл (эсвэл)
9.	буюу	25-р зүйлийн 3. Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь нийтийн эмх замбараагүй байдал үүсч	эсхүл (эсвэл)
10.	буюу	31-р зүйлийн 2. Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлнэ.	эсхүл (эсвэл)
11.	буюу	33-р зүйлийн 1.1. Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих.	эсхүл (эсвэл)
12.	буюу	33-р зүйлийн 1.5. Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах	эсхүл (эсвэл)
13.	буюу	33-р зүйлийн 1.11. бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах	эсхүл (эсвэл)
14.	буюу	33-р зүйлийн 1.12. улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах	эсхүл (эсвэл)
15.	буюу	33-р зүйлийн 1.13. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно.	эсхүл (эсвэл)
16.	буюу	34-р зүйлийн 2. Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.	эсхүл (эсвэл)

⁶ Монгол Улсын Үндсэн хуульд буюу холбоос 24 удаа тохиолдож байгаагаас хоёр л удаа тодосгох утгаар (бусад 22 тохиолдолд буруу хэрэглэсэн) зөв хэрэглэжээ. Тиймийн тул эл хүснэгтийн утга хэсэгт зөвөөр солин найруулах боломжтой холбоосыг бичив.

17.	буюу	45-р зүйлийн 2. Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.	эсхүл (эсвэл)
18.	буюу	48-р зүйлийн 1. Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд	тодосгох
19.	буюу	50-р зүйлийн 2. Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.	эсхүл (эсвэл)
20.	буюу	60-р зүйлийн 3. Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга	эсхүл (эсвэл)
21.	буюу	61-р зүйлийн 3. огцрох хүсэлтээ зохих Хурал, Ерөнхий сайд буюу харьяалах дээд шатны Засаг даргад гаргаж болно.	эсхүл (эсвэл)
22.	буюу	61-р зүйлийн 4. Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно.	эсхүл (эсвэл)
23.	буюу	66-р зүйлийн 1. Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.	эсхүл (эсвэл)
24.	буюу	70-р зүйлийн 2. Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны усан бичин жилийн хаврын тэргүүн хар барс сарын шинийн есний идрийн барилдлагаатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө.	тодосгох
Эсхүл (эсвэл) холбоос			
1.	эсхүл	22-р зүйлийн 2. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзэж, эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөж санал болгосон	болзон сонгох
2.	эсхүл	22-р зүйлийн 3. Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд анх оруулснаас хойш дөчин тав хоногийн дотор, эсхүл Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулснаас, түүнчлэн дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцорсонд тооцсоноос хойш гуч хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргана.	болзон сонгох
3.	эсхүл	22-р зүйлийн 4. 4.Энэ зүйлийн 2, эсхүл 3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр гаргаснаас хойш Улсын Их Хурал арав хоногийн дотор сонгуулийг товлон зарлаж, жар хоногийн дотор явуулна.	болзон сонгох
4.	эсхүл	25-р зүйлийн 1.18. онц болон дайны байдал зарлах, эсхүл энэ тухай гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, хүчингүй болгох.	болзон сонгох
5.	эсхүл	25-р зүйлийн 3. бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, эсхүл тийнхүү халдах нь бодитой болсон үед дайны байдал зарлаж болно.	болзон сонгох

6.	эсхүл	27-р зүйлийн 3. Улсын Их Хурлын гишүүдийн гуравны нэгээс дээшхийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган чуулж болно.	болзон сонгох
7.	эсхүл	27-р зүйлийн 7. Үндсэн хууль, бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн бол нууц санал хураалт явуулна.	болзон сонгох
8.	эсхүл	51-р зүйлийн 4. Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.	болзон сонгох
Түүнчлэн холбоос			
1.	түүнчлэн	6-р зүйлийн 2. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.	лавшруулах
2.	түүнчлэн	6-р зүйлийн 3. Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно.	лавшруулах
3.	түүнчлэн	19-р зүйлийн 2. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.	лавшруулах
4.	түүнчлэн	22-р зүйлийн 3. Ерөнхийлөгч Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд анх оруулснаас хойш дөчин тав хоногийн дотор, эсхүл Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулснаас, түүнчлэн дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцорсонд тооцсоноос хойш гуч хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргана.	лавшруулах
5.	түүнчлэн	33-р зүйлийн 1.12. онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх.-	лавшруулах
6.	түүнчлэн	38-р зүйлийн 2.3. салбарын ба салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх	лавшруулах
7.	түүнчлэн	38-р зүйлийн 2.9. Улсын Их Хуралтай зөвшилцөж дараа соёрхон батлуулахаар Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, түүнчлэн Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, цуцлах.	лавшруулах
8.	түүнчлэн	57-р зүйлийн 2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.	лавшруулах

9	түүнчлэн	66-р зүйлийн 2.1. хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, <i>түүнчлэн</i> Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх	лавшруулах
10.	түүнчлэн	66-р зүйлийн 4. Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, <i>түүнчлэн</i> Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно.	лавшруулах
Боловч холбоос			
1.	боловч	16-р зүйлийн 13. <i>Хэнд боловч</i> эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.	олны утгаар
2.	боловч	19-р зүйлийн 2. <i>хэнд боловч</i> эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.	олны утгаар
3.	боловч	49-р зүйлийн 2. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн <i>хэн боловч</i> шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.	онцлох
Учир холбоос			
1.	учир	эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан	Салангид өгүүлбэрүүдийг зэрэгцүүлэн холбох үүргээр
2.	учир	16-р зүйлийн 1. амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;	Салангид өгүүлбэрүүдийг зэрэгцүүлэн холбох үүргээр